



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136, Утас: 7012-8801,
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,
<http://www.chd.mohs.mn>

2022.05.10 № 362
танай _____-ны № _____-т

Хяналт-шинжилгээ, үнэлгээний
зөвлөмж хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ын дагуу эмнэлзүйн сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагын үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, холбогдох санал зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Зөвлөмжийн дагуу сургалтын үйл ажиллагааг сайжруулах тал дээр онцгой анхаарч, 2022 оны 05 дугаар сарын 15-ны дотор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, баримт бичгийг албан бичгээр ирүүлнэ үү.

Холбогдох утас: Үндсэн мэргэшлийн сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Л.Оюунбилэг – 9981 7878

Хавсралт хуудастай.

Хүндэтгэсэн,

ЗАХИРГАА, САНХҮҮ, УДИРДЛАГЫН
АЛБАНЫ ДАРГА



Л.ОЮУНЧИМЭГ

142204000089

**УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЗҮЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ДҮН, ЗӨВЛӨМЖ**

2022 оны 05 сарын 05

№ 19

Улаанбаатар хот

Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго

Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагын үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, сургалтын зохион байгуулалт, чанар, үр дүнг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж хүргүүлэн дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагын үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагааг үнэлэхдээ Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”, ЭМС-ын 2020 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан “Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам”, ЭМС-ын 2021 оны А/20 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загвар”-ыг тус тус үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.

Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий 23 байгууллагын үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагаа, эрх зүйн орчин болон резидент эмчийн цалин, сургалтын төлбөрийн зарцуулалт гэсэн 3 чиглэлийн хүрээнд хяналт - шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн эмнэлзүйн сургалтын үйл ажиллагаатай холбоотой үүсч буй резидент эмчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин, баримт бичгийг судлах;
2. Төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагын үндсэн мэргэшлийн эмнэлзүйн сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
3. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн эмнэлзүйн сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад олгосон сургалтын зардал, цалингийн санхүүжилтийн зарцуулалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Үнэлгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2022 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу ажлын хэсэг эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий 23 байгууллагын төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаатай холбоотой баримт, бичиг, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан болон сургалтын орчин нөхцөлийг үнэлэн санамсаргүй түүврийн аргаар Эмнэлзүйн сургагч багш, суралцаж буй резидент эмчийг сонгон ярилцлага зохион байгуулах, тодруулга авах зэрэг үндсэн аргуудыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Үндсэн мэргэшлийн 11 чиглэлээр, төрөлжсөн мэргэшлийн 46 чиглэлээр төгсөлтийн дараах сургалт зохион байгуулдаг. Үндсэн мэргэшилээр жилд 320 орчим, төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр жилд 300 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтаар бэлтгэдэг.

Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай баримт бичгүүдийг эрх бүхий албан тушаалтны баталсан журмын дагуу боловсруулан мөрддөг. Захирлын бүтэц орон тоо баталсан тушаалд Сургалт эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал, сургалт эрдэм шинжилгээ хамтын ажиллагааны алба 4 хүний бүрэлдэхүүнтэй баталсан. Одоо ажиллаж байгаа дэд захирал, албаны дарга байхгүй, үндсэн мэргэшлийн сургалт хариуцсан мэргэжилтэн -1, төрөлжсөн мэргэшлийн сургалт хариуцсан мэргэжилтэн -1. Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн болон номын санч нь тус албанд харьяалагддаг хэдий ч сургалтын үйл ажиллагаанд оролцдоггүй. Сургалт удирдах багш - координатор багш томилох тухай захирлын тушаалаар батлуулж суралцагсдыг дагалдуулдаг.

Үндсэн мэргэшлийн эмчийн эзэмших цогц чадамжийг 11 чиглэлээр боловсруулсан. Суралцагч эмчийн гарын авлага, logbook байхгүй, дүнгийн дэвтэртэй. Суралцагч эмчийн өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэлийг резидент хариуцсан багш баталгаажуулж, сургалтын алба хяналт тавьдаг хэдий ч эмч нар үнэлгээ хийхдээ өөр өөр арга барилаар тойролтыг үнэлдэг. Сургалтын хөтөлбөр үндсэн тусламж үйлчилгээний чиглэлтэй уялдсан, суралцах шаардлагатай сэдвүүд тусгагдсан, сургалтын хөтөлбөр бүрэн биелэгдэх боломжтой. Хөтөлбөрийн шинэчлэл хийх шаардлагатай. Сургалтын зохицуулагч багшийн хяналт сайн. Сургалт эрхлэх сүлжээ эмнэлгүүдтэй албан ёсоор гэрээ хийгдсэн. Сүлжээ эмнэлгүүдэд тойролт хийх хугацаа тодорхой бус байдаг. Эмнэлзүйн сургагч багшийн сургалтад эмч мэргэжилтнүүд үе шаттай хамрагддаг. Эмнэлзүйн сургагч багшийн хичээл заасан бүртгэл байдаггүй.

Суралцагч эмч нарыг эмч нарын ярианд оролцдоггүй /заалны багтаамжгүй/, тасгийн ярианд оролцдог. Багш суралцагсдын хоорондын харилцаа харилцан адилгүй. Суралцагч эмч нар хуваарийн дагуу жижүүрт хонодог. Сургалтын албанаас резидент эмч нарт зориулсан идэвхижүүлэх үйл ажиллагаа зохион байгуулдаггүй. Сургалт, конференци, хэлэлцүүлэгт резидент эмч нарыг хамрууладаг хэдий ч бүртгэл баримт байхгүй. Сургалтын албанд санал хүсэлт гаргахад хүлээн авч шийдвэрлэдэг.

Нийгмийн хангамжийн хувьд нэг удаагийн хамгаалах хэрэгсэлээр /маск, малгай/ Ковид-19-ын үед дэмжлэг үзүүлсэн. Коронавирусын эсрэг дархлаажуулалтад хамруулсан.

Резидент эмч нарт зориулсан өрөөтэй, өрөөг тохижуулсан, унтаж амрах давхар ортой /2 ширхэг/, хувцасны локертой. Тойролт хийх тасаг нэгжид резидент эмч нарт зориулсан өрөө тасалгаа сандал ширээ байдаггүй. Цахим өвчний түүх нээх, тэмдэглэл

хөтлөх зэрэгт үндсэн эмч нарын ширээ сандал, компьютерийг хэрэглэдэг. Номын сантай, резидент эмч нар номын сангийн картаар үйлчлүүлдэг.

Үнэлгээний дүн:

	Ерөнхий үзүүлэлт	Үнэлгээний дүн
1.	Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх байгууллагын удирдлага, зохион байгуулалт	Гүйцээх шаардлагатай
2.	Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх байгууллагын сургалтын орчин	Гүйцээх шаардлагатай
3.	Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх байгууллагаас суралцагчдад үзүүлэх дэмжлэг	Гүйцээх шаардлагатай
4.	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хэрэгжилт	Гүйцээх шаардлагатай
5.	Суралцагч-эмчид зааж чиглүүлэх тогтолцоо	Зохистой
6.	Суралцагч эмчийн үнэлгээ	Зохистой

Дөрөв. Санал, зөвлөмж

4.1.Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн эмнэлзүйн сургалтын үйл ажиллагаатай холбоотой үүсч буй резидент эмчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин, баримт бичгийн талаар:

Үндсэн мэргэшлээр суралцах эмнэлгийн мэргэжилтэн нь Эрүүл мэндийн тухай хуулийн 25.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн харилцаанд шилжиж байгаатай холбогдуулан СЭБ-д дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- 4.1.1. Элсэн суралцаж буй резидент эмчтэй дагалднаар суралцах Хөдөлмөрийн гэрээг яаралтай шинэчлэн байгуулж, түүнд дараах зохицуулалтыг тусгах. Тухайлбал:
 - эзэмших мэргэшил, ажлын байран дээр ажиллавал зохих цаг, суралцах цаг, эзэмшвэл зохих мэргэшлийн онолын болон дадлага, ур чадварыг тодорхойлсон сургалтын хөтөлбөрийг хавсаргах
 - цалин хөлсийг цагийн бүртгэл, сургагч багшийн үнэлгээ, резидент эмчийн тайланг үндэслэн олгох
 - сард 2-оос доошгүй удаа цалин хөлсийг олгох хуваарьт өдрүүдийг тогтоох
 - гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэх, түүний дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулах.
- 4.1.2. Ажлын байрны тодорхойлолтыг үндсэн мэргэшлийн чиглэл бүрээр боловсруулж, 2022 оны 5 сард багтаан батлах
- 4.1.3. Резидент эмчийн бие даан үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг сургалтын хөтөлбөр, тойролт бүртэй уялдуулан мэргэшлийн чиглэл тус бүрээр 2022 оны 5 сард багтаан баталж, мөрдүүлэх
- 4.1.4. Хөдөлмөрийн дотоод журамд дагалднаар суралцаж буй резидент эмч нарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой зохицуулалтыг тусган хэрэгжүүлэх

- 4.1.5. Хөдөлмөрийн гэрээ, Ажлын байрны тодорхойлолт зэргийг Резидент эмчид хүлээлгэн өгөх, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай холбоотой бусад хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг резидент эмчид батлагдсан даруй танилцуулах, баримтжуулах
- 4.1.6. Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааны 2021 оны тайланг 5 сарын 15-ны дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд ирүүлэх, цаашид жил бүр журамд заасан хугацаанд ирүүлж байх
- 4.1.7. Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаа, резидент эмчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой тушаал, шийдвэрийг холбогдох журам, стандартын дагуу баримтжуулах, баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах
- 4.1.8. Багш нар, резидент эмч нарт цалин олгох тушаал зэрэг холбогдох үйл явцыг тухай бүр баримтжуулан, баримт бичгийг зохион бүрдүүлж, хөтлөх хэргийн жагсаалтад оруулан, бүртгэл үүсгэн тогтмол хөтлөх
- 4.1.9. Төгсөлтийн дараах сургалтын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, тогтвортой ажиллуулах, хөдөлмөрийн харилцааны талаар мэдлэг олгох
- 4.1.10. Резидент эмчийг сургалтаас хассан, чөлөө олгосон зэрэг бүртгэл хөтлөх
- 4.1.11. Сургалт эрхлэх чадавхи, нөөцөө үнэн бодитоор танилцуулж, суралцагсдын тоог гаргахад ЭМХТ-тэй нягт хамтран ажиллах
- 4.1.12. Сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр:
 - Төгсөлтийн дараах сургалт зохион байгуулахаар бусад СЭБ-уудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хагас жил тутам дүгнэх
 - Үндсэн суралцагсадын сургалтыг чанартай зохион байгуулахад өөрсдийн нөөцийг бүрэн зарцуулах
 - Компьютер, тоног төхөөрөмжөөр резидент эмч нарыг ханган, суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэх

4.2. Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагын үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр:

- 4.2.1. **Төгсөлтийн дараах сургалт эрхлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт:**
 - Байгууллагын стратегид тусгасан сургалттай холбоотой ажлуудыг, урт болон богино хугацааны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангах, тайланг баримтжуулах
 - Сургалтын албаны бүтэц орон тоо, хавсран гүйцэтгэж буй ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолтод тусгасан ажил үүргийг эргэн харах, ачааллыг бууруулах / үндсэн болон төрөлжсөн мэргэшил, дээшлүүлэх чиглэлээр олон тооны элсэгч авдаг том сургалт эрхлэх байгууллага тул/
 - Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, төгсөлтийн дараах сургалттай холбоотой үйл ажиллагааг хэлэлцүүлэх, шийдвэр, хурлын тэмдэглэлийг баримтжуулах
- 4.2.2. **Төгсөлтийн дараах сургалт эрхлэгч байгууллагын сургалтын орчин**
 Сургалтын орчин нөхцлийг сайжруулах, Үүнд:
 - Тойролт хийх тасаг нэгжид резидент эмч нарт зориулсан өрөө тасалгаа гаргах, сандал ширээ байршуулах, цахим өвчний түүх нээх, тэмдэглэл хөтлөх зэрэгт бэрхшээлтэй байдаг асуудлыг шийдвэрлэх,
 - Тодорхой /онцлогтой/ мэргэшлийн чиглэлээр суралцаж буй резидент эмч нарт тасаг нэгжид нь байрших өрөөг зайлшгүй гаргах, тохижуулах /мэс

засал гэх мэт чиглэлээр суралцагсад жижүүрт хонох зэрэг тохиолдолд нэгдсэн байрнаас дуудах, очиж амрахад хүндрэл үүсдэг/

- Эмнэлзүйн сургалтын өрөө, гардан үйлдэл хийх манекан, муляж бүхий симуляцийн төв байгуулах, сургалтын үйл ажиллагаанд тогтмол ашиглах зохион байгуулалттайгаар бий болгох,
- Номын санг өргөжүүлэх, шинэ хэвлэгдсэн ном, товхимолоор баяжуулах, цахим номын сан үүсгэж фондыг нэмэх,
- Эмч нарт зориулсан амралтын болон хичээл давтах өрөө тасалгаа тасаг нэгжид харилцан адилгүй байгаа тул жишиг бүхий тасаг нэгж /Эмнэлзүйн эмгэг судлал/-ийн хэмжээнд тохижуулах, унших, хичээл давтах өрөө тасалгааг зориулан гаргах

4.2.3. Төгсөлтийн дараах сургалт эрхлэгч байгууллага дээрх суралцагчдын дэмжлэгт орчин

- Тусламж үйлчилгээний чанар, хөдөлмөр аюулгүй байдал, халдвар хамгааллын нэгж нь төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд оролцож, сургалтын албатай хамтран ажиллах, суралцагч, сургалт удирдах багшийн оролцоог журамдаа нэмэлтээр тусган албажуулах
- Сургалтын шинэчилсэн журамд суралцагч эмчийн нийгмийн асуудал, сургалтын хөтөлбөрийг хангалтгүй дүнтэй дүүргэсэн тохиолдолд суралцагч эмчийн төлөө авах арга хэмжээг журамд тодорхой тусгах, батлуулах
- Суралцагчийг үнэлэх үнэлгээг тодорхойлж, сургалт удирдах багш нарт тодорхой болгох,
- Эмнэлзүйн конференцид суралцагсдыг хамруулж, тохиолдол хяналт, journal club хэлэлцүүлэг хийх, баримтжуулах
- Жилд 1 удаа онол, дадлага тайлан хамгаалуулдаг үйл ажиллагааг баримтжуулах
- Суралцагсдыг нэгдсэн байдлаар 306 хэм, minisex зэрэг үнэлгээгээр үнэлэх,
- Суралцагсдын идэвхийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах /эмнэлзүйн ба эмнэлзүйн бус, спортын гэх мэт/
- Хөтөлбөрийн агуулга, тойролт хийх хугацаа, төлөвлөгөөг резидент эмч нарт тодорхой тайлбарлах

4.2.4. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө

Сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулж буй ажлын хэсгийн гишүүдтэй уулзалт хийх, хөтөлбөрт оруулах санал боловсруулж саналыг тусгуулах,

4.2.5. Суралцагч-эмчид зааж чиглүүлэх тогтолцоо

- Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд бусад эмнэлзүйн сургагч багш нарыг татан оролцуулах
- Хөтөлбөрийн шинэчлэл, үнэлгээний арга барилыг шинэчлэхэд сургагч багш нарын оролцоог нэмэгдүүлэх

4.3. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн эмнэлзүйн сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад олгосон сургалтын зардал, цалингийн санхүүжилтийн зарцуулалтын чиглэлээр:

4.3.1. Сургалт эрхлэх байгууллага нь өөрийн төсөвтөө дараах зардлыг тусган, шийдвэрлэх:

- Зайлшгүй шаардлагаар илүү цагаар болон шөнийн ээлжинд ажилласан

- үеийн нэмэгдэл хөлс
- Ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, ээлжийн амралтын цалин
- 4.3.2. Төгсөлтийн дараах сургалтын санхүүгийн 2021 оны тайланг 5 сарын 15-ны дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд ирүүлэх, цаашид жил бүр журамд заасан хугацаанд ирүүлж байх
- 4.3.3. ЭМС, Сангийн сайд "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 2015 оны 97/56 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан жишгийн дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс шилжүүлсэн санхүүжилтийг дараах байдлаар зарцуулж, холбогдох тушаал шийдвэрийг баримтжуулж байх. Үүнд:
- Эмнэлзүйн сургагч багшийн ажлын хөлсөнд 45%,
 - Сургалтын материалд 35%,
 - Эмнэлзүйн сургалтын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангахад 15%,
 - Элсэлт, төгсөлтийн шалгалт зохион байгуулах, үнэмлэх, гэрчилгээг хэвлүүлэхтэй холбоотой зардалд 5%.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

2022 он